



ЛҮН СУМЫН НЕҮЙЛЧИЛГЭЭ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Залруулаагүй алдаа	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	10

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272585

Аудитын менежер
О.Амаржаргал
Утас: 70273463

Шинжээч Ц.Хишигжаргал
Утас: 70273204
И-мэйл khj_616@yahoo.com

Хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Лүн сумын НЕҮйлчилгээний 2013 оны Санхүүгийн Тайланд**ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Лүн сумын НЕҮйлчилгээний 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Лүн сумын НЕҮйлчилгээний төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаах бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Лүн сумын удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулвал:**

- ✓ Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг торуулвал:

Дотоод хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй хийгээгүй байна.

- ✓ Авлагаар тусгах мөнгийг, Бараа материалын тайланд үлдэгдэлээр тусгасан байна.
- ✓ Мал ээмэгжүүлэх бүртгэлжүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан, уг ажлын явцыг буруу мэдээллэж тайлагнасан МЭҮТасгийн дарга Н.Төмөртуяад хариуцлага тооцох санал хүргүүлэв.
- ✓ ЕБСургуулийн дотуур байрны инженер геологийн судалгааны ажлын зардал 2077.1 мянган төгрөгийг, уг барилгын төсөвт тусгуулж, ЕБСургуулиас буцаан авах акт бичив.
- ✓ Данс бүртгэлд тусгаагүй 675.2 мянган төгрөгийг ЗДТГазраар төлүүлж аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт бичив.

ЕМ, Санхүүгийн албанаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн хөрөнгө бэлтгэж тайлагнахтай холбогдон гарсан зөрчлүүдийг арилгуулахаар акт, албан

шаардлага бичиж тус тайланд **хязгаарлалттай санал** дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа Тэргүүлэх Аудитор 2014.03.28-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч М.Баттунгалаг нар бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Үндэсний Аудитын Газрын Харьяа Төв
Аймгийн Аудитын Газар

2014.03.19

Танилцуулга

1. Бид Лүн сумын НЕҮйлчилгээний 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж дуусаж байна. Сумын удирдлагуудад аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Лүн сумын НЕҮйлчилгээний удирдлагууд тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Лүн сумын ЗДТГазрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Лүн сумын НЕҮйлчилгээний удирдлагад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараах түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Лүн сумын НЕҮ-ний удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналт шалгалтын талаар

МУ-ын ЗГазрын 2011.11.09-ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам батлагдсан байна. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” –ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заасан байдаг

Дотоод хяналт шалгалтыг хэрхэн хийж байгаа талаар шалгахад сумын Засаг даргын 2011.02.28-ний өдрийн 29 тоот захирамжаар сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг Төрийн сангийн төлөөлөгчөөр ахлуулан 5 хүний бүрэлдхүүнтэй байгуулсан байна.

Тус баг нь хийх хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөө гарган батлуулсан ба 1,2-р улиралын санхүүгийн баримтанд анхан шатны баримтын бүрдэл, хөрөнгийн тооллого тооцоо бодолтыг шалгаж ня-бо нарын ажлыг дүгнэж ажилласан гэх боловч энэ тухай тайлан байхгүй байна.

Жилийн эцэст дотоод хяналтын шалгалт хийгдсэн тайлан авчраагүй ба хяналт шалгалт хийсэн тухай тайланг тухай бүрд нь бичиж тайлан дүнг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хугацаатай үүрэг өгч биелэлтийг шалган ажиллах хэрэгтэй байна. Дотоод хяналт шалгалтын ажлыг үр дүнтэй хийгээгүй байна.

МУ-ын ЗГазрын 2011.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллахыг дахин зөвлөж байна.

2. Орлого санхүүжилтийн талаар

Орон нутгийн орлого тайлант онд **120942.0** мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс **12918.2** мянган төгрөгөөр буюу **112** хувиар биелүүлсэн байна. Лүн сумын НЕҮйлчилгээний үйл ажиллагаанд төсвөөс санхүүжүүлсэн 181231.2 мянган төгрөг, орон нутгын орлогоос 132241.7 мянган төгрөг, өөрийн орлогоос 441.0 мянган төгрөг, дамжсан гүйлгээ 106320.2 мянган төгрөг нийт 420234.1 мянган төгрөгийн орлого санхүүгийн тайланд бүрэн тусгагдсан байна.

ЗДТГазар болон багийн Мөнгөн гүйлгээний харилцах дансаар дамжсан 106320.2 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд орлогоор тайлагнаж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулга хийсэн байна. 2010, 2011 онуудын давсан орлогоос 42070.0 мянган төгрөгийг 2013 оны 4-р сарын 11 өдрийн 01 тоот тогтоолоор тодотгож, санхүүжилтыг хавсралтаар баталсан байна. Тайлант онд орлого санхүүжилтыг зөв бүртгэж тайланд тусгасан байна.

3. Үндсэн хөрөнгө

НЕҮйлчилгээний үндсэн хөрөнө нь оны эхэнд 848109.4 мянган төгрөг дээр 223086.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 40806.0 мянган төгрөгөөр хасагдаж жилийн эцэст 1030389.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд: Барилга байгууламж:

Гүний худаг 3ш 41899.6 мянган төгрөг, Зохиомол хээлтийн функт 13867.5 мянган төгрөг, Малын тэжээл тариалах талбай 3ш 12100.0 мянган төгрөг, Үдлэг багийн соёлын төвийн барилга 20.0 сая төгрөг, Цогт-өндөр багийн төвийн барилга 20.0 сая төгрөг, Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт 4500.0 мянган төгрөг нийт 125482.1 мянган төгрөг нэмэгдэсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

Авто тээврийн хэрэгсэл:

МЭҮТасагт УАЗ додик автомашин 19990.0 мянган төгрөг, Цагдаагийн мотоцикль 1ш 1360.7 мянган төгрөг, БОХУБайцаагчын мотоцикль 1 ш 910.0 мянган төгрөг, Хогны машин ПОРЛАНД автомашин 19.0 сая төгрөг нийт 41260.7 мянган төгрөгөөр нэмэгдэсэн байна.

Машин тоног төхөөрөмж:

Төсвийн хөрөнгөөр 1699.9 мянган төгрөг, Багийн засаг дарга нарт компьютер техник хэрэгсэл 3184.8 мянган төгрөг, Ус цэвэршүүлэх төхөөрөмж 8830.0 мянган төгрөг, Багийн эмчид компьютер 799.0 мянган төгрөг, тооллогоор агропаркын чиргүүл, хадуурын үнэ 2090.0 мянган төгрөг, хандиваар принтер, GPS төхөөрөмж 679.9 мянган төгрөг нийт 1783.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогод авч данс бүртгэлд тусгасан байна. Тайланд онд сумын ИТХурлын тэргүүлэгчдын 2013 оны 12 сарын 26-ны 32 тоот тогтоолоор 6139.7 мянган төгрөгийн хөрөнгө актлах шийдвэр гаргасан байна.

Тавилга эд хогшил:

Тайланд онд сумын ИТХурлын тэргүүлэгчдын 2013 оны 12 сарын 26-ны 32 тоот тогтоолоор 1746.5 мянган төгрөгийн хөрөнгө актлах шийдвэр гаргасан байна.

Биет бус хөрөнгө:

Сум хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө 25.0 сая төгрөгөөр хийлгэж орлогод авсан байна.

✓ Актлагдсан хөрөнгийг Өмч хамгаалах комиссын хяналтаар складаас гаргаж устгах

- ✓ Урсгал засварын зардалаас 1699.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

4.Бараа материал.

Тайлант онд бараа материалын тайлангаар НЕҮйлчилгээний байгууллагууд 26257.3 мянган төгрөгийн орлогын, 40002.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст 17202.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Бараа материалын дансаар нүүрсний үнэ 8368.5 мянган төгрөг орлого зарлагын гүйлгээнд тусгасан боловч Өнөр-мандах ХХК-д 3405.0 мянган төгрөг урьдчилан шилжүүлж нүүрсийг ирээгүй байхад бараа материалд орлого болгосон байна. Шатахууны үнэ 14603.4 мянган төгрөг зарцуулсан ба бараа материалын дансанд тоо хэмжээ тодорхой бус мөнгөн дүнгээр орлого зарлага болгосон байна. Жилийн эцэст шатахууны үнэ ЗДТГазар болон багийн 404.8 мянган төгрөгийн шатахууны авлагатай байхад бараа материалын дансанд орлого болгож үлдэгдэлээр тусгасан байна. Энэ нь НББүртгэлийн тухай хуулийн 4.1.2. “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” 9.1, “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” гэснийг зөрчиж байна. Мөн бараа материалын дансанд үхрийн гэрчилгээ 18400 ширхэг 2796.8 мянган төгрөг, хонины гэрчилгээ 5600 ширхэг 795.7 мянган төгрөг, ямааны гэрчилгээ 2000 мянган төгрөг 299.4 мянган төгрөг нийт 3891.9 мянган төгрөгийн үлдэгдэл байна. МЭҮТасаг нь мал ээмэгжүүлэх бүртгэлжүүлэх ажил хийгдэж дууссан гэсэн тайлан бичиж холбогдох зардлыг бүрэн авч зарцуулсан байгаатай нийцэхгүй байна.

- ✓ Авлагаар тусгах мөнгийг, Бараа материалын тайланд үлдэгдэлээр тусгасан байна.
- ✓ Мал ээмэгжүүлэх бүртгэлжүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан, уг ажлын явцыг буруу мэдээллэж тайлагнасан МЭҮТасгийн дарга Н.Төмөртуяад хариуцлага тооцох санал хүргүүлэв.

5.Цалингийн талаар

Цалингийн сан үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангаар НЕҮйлчилгээний байгууллагуудад нийт 182162.3 мянган төгрөг тайлагнагдсан ня-бо-гийн гаргаж ирүүлсэн цалингийн сангийн судалгаагаар 180140.1 мянган төгрөг буюу 2022.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Цалингийн зардлаас Ахмадын хорооны дарга 600.0 мянган төгрөг, НББодлого 335.0 мянган төгрөг, Сантехникийн засвар хийлэгсэн гэрээний хөлс 500.0 мянган төгрөг, ажил олгогчоос өгсөн листний мөнгө 587.2 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. ЗДТГазрын 4-н албан хаагч ажил хавсран гүйцэтгэж байна. Иймээс батлагдсан орон тооны дагуу ажилчдыг бүрэн ажиллуулах ажлын байрны сул орон тоо гаргахгүй байх шаардлагатай байна. ЗДТГазрын 4-н албан хаагч ажил хавсран гүйцэтгэж байна. Иймээс батлагдсан орон тооны дагуу ажилчдыг бүрэн ажиллуулах ажлын байрны сул орон тоо гаргахгүй байх шаардлагатай байна.

- ✓ ЗДТГазрын даргаар эрх бүхий албан тушаалтаны нэмэгдэл 618996 төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт бичив.

6.Бараа үйлчилгээний зардал

Бараа ажил үйлчилгээний зардал 55480.1 мянган төгрөг батлагдсан ба төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 52034.3 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнээс түлш халаалтын зардал 9353.2 мянган төгрөг, тээвэр шатахуун 14227.9 мянган төгрөг

зарцуулсан байна. Нүүрсийг вагоноор тээвэрлэж авдаг ба орлогод авсан хэмжээ нь уурын зуухны хүчин чадал болон зарцуулалтын нормативтай тохирч байна.

Шатахууныг албан тушаалтаны гүйцэтгэх ажлын чиглэл маршрутад үндэслэн захиалгын хуудсаар олгодог ба захиалагч нь ажил гүйцэтгэсэн талаарх тэмдэглэгээг бичиж баталгаажуулсаны үндсэн дээр зохих зардалд тусгаж байхаар журам тогтоосон байна. Гэвч зарим тохиолдолд ажил гүйцэтгэсэн талаарх тэмдэглэгээ бичээгүй байна. Албан томилолтыг ЗДТГазрын дарга олгож ажил гүйцэтгэсэн тайланг үндэслэн зохих хувиар бодож олгох зөвшөөрлийг нягтлан бодогчид өгдөг байна.

Аудитаар томилолтын мөнгийг бүрдэл болоогүй баримтаар зөвшөөрөлгүй олгосон, ажил гүйцэтгэсэн тухай тайлан бичээгүй байхад мөнгийг бодож олгосон зөрчил илэрлээ. Үүнд: Засаг дарга Д.Ганбаяр 2013/01/13-ны 2 хоног 58.0 мянган төгрөг, МЭҮТасгийн дарга Н.Төмөртуяа Дарханд 2013 /08/22-ны 2 хоног 58.0 мянган төгрөг нийт 116.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичив.

- ✓ Авто машинаар ажил гүйцэтгэсэн тухай тайлан тэмдэглэгээ жолоочийн замын хуудас бичигдээгүй байвал олгосон шатахууныг захиалагч болон жолоочоор төлүүлж байх нь зүйтэй юм.

7.Мөнгөн хөрөнгө

Тайлант онд харилцахаас кассд 15322.5 мянган төгрөг авч зарцуулсанаас БХамгаалагчдын гарт олгох цалин 4761.2 мянган төгрөг, баяр наадмын зардалд 5.0 сая төгрөг, ХАА тооллогын 2051.5 мянган төгрөг, томилолтод 489.5 мянган төгрөг, Ахмадын хорооны урамшуулалд 505.0 мянган төгрөг, бусад тэтгэмж зэрэг 2515.3 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан байна.

Сумын ИТХурлын 2013 оны 4-р сарын 11 хуралдаанаар өмнөх оны давсан орлого буюу шилжих үлдэгдлээс 42070.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр жагсаалтаар баталсан байна. Энэ санхүүжилтын нэг хэсэг болох Сумын төвийн гэрэлтүүлэг хийхэд 9567.0 мянган төгрөг баталсан байна. Тендерийн шалгаруулалтаар Иргэн С.Нямаа шалгарч 2013/08/03- ны өдөр урьдчилгаа 80% санхүүжилт 7600.0 мянган төгрөг авсан боловч 2013/09/17 нд гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзан 7600.0 мянган төгрөгийг төрийн сангийн харилцах дансанд буцааж тушаасан байна. Иймд иргэн С.Нямаагаар дээрх мөнгийг ашигласан хугацаанд /47 хоногт/ арилжааны банкны зээлийн сарын хүү/3%-иар/-гээр тооцож 357200 төгрөгийг нөхөн төлүүлэхийг Засаг дарга Д.Ганбаярт хариуцуулан төлбөрийн акт бичив.

- ✓ Сумын Засаг дарга нь ИТХурлаар хэлэцэж тодотгол хийгээгүй зардлуудыг давсан орлогоос дур мэдэн санхүүжүүлсэн байна.
- ✓ ЕБСургуулийн дотуур байрны инженер геологийн судалгааны ажлын зардал 2077.1 мянган төгрөгийг, уг барилгын төсөвт тусгуулж, ЕБСургуулиас буцаан авах акт бичив.

8.Авлага ,өглөгийн талаар

Тайлант онд НДХэлтэстэй тооцоо нийлээгүйгээс ИТХурлын цалингийн шимтгэлд 37.6 мянган төгрөгийн өглөгтэй, ЗДТГазрын цалингийн шимтгэл 270.4 мянган төгрөгийн авлагтай тайлагнагдсан байна. Дээрх өглөг, авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна. Зуунмод ХҮТөв-тэй тооцоо нийлж 219.2 мянган төгрөгийн авлагаар тохирч данс бүртгэлд тусгасан байна.

Татварын хэлтэстэй тооцоо нийлж өглөг авлагагүй тохирсон байна. Шатахууны үнийг нэхэмжлэхийн дүнгээс хамааралгүй тогтмол дүнгээр шилжүүлж байгаа нь өглөг авлага үүсгэхэд нөлөөлж байна. Шатахуун түгээх станцтай тухай бүр тооцоо нийлж өглөг авлагыг тохирдог байна. Шатахууны тооцоог Гурван цагаан далай ХХК-тай тооцоо нийлж 404.8 мянган төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна. Аж ахуйн материалыг Хулангийн хишиг ХХК-иас авч тухай бүр тооцоог хийдэг байна.

Жилийн эцсийн тайланд 675.2 мянган төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь ТБУСТХуулийн 17-р зүйлийн 1.7дахь заалт “Төсвийн санхүүжилтийг үр ашигтай явуулна”, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 4,1-д “төсвийн жил нь тухайн оны 1-р сарын 1-ний өдрөөс эхэлж 12-р сарын 31-ээр дуусгавар болно” гэж заасан заалтууд нь тухайн жилийн төсөв нь зөвхөн тухайн жилдээ зарцуулах харилцааг зохицуулана.

✓ Данс бүртгэлд тусгаагүй 675.2 мянган төгрөгийг ЗДТГазраар төлүүлж аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт бичив.

9.Тусгай зориулалттай сангуудын талаар

Лүн сум оны эхэнд 5 санд нийт 45672.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 187940.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 50034.8 мянган төгрөг зарцуулж, оны эцэст 183578.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мал хамгаалах сан:

Тайлант оны эхэнд 7412.4 мянган төгрөг байсанаас Алтан-мандал ХХК-нд өвс тэжээлийн үнэнд 5000.0 мянган төгрөг зарцуулсан байна. Гэрээний заалтууд тодорхой биш өвс тэжээлийг данс бүртгэлд тусгаагүй, тооцоо хийгээгүй байна. Алтан-мандал ХХК-хийсэн гэрээний дагуу 2013/05/06 наар дуусгавар болгон 5000.0 мянган төгрөгийг Мал хамгаалах сангийн дансанд оруулах, энэ хугацаанаас хэтэрсэн тохиолдолд өдөр тутамд зохих хүүг тооцож /сарын 4%/ авах нь зүйтэй байна.

ГХУСЭргийлэх сан:

Тус сангийн эхний үлдэгдэл 81.7 мянган төгрөг дээр ИТХурлын төсвөөс санхүүжүүлсэн 2116.2 мянган төгрөг нэмэгдэж хууль сурталчилах тэмцээний зардалд 42.0 мянган төгрөг, ОНБайцаагчийн урамшуулалд 180.0 мянган төгрөг нийт 222.0 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 1975.9 мянган төгрөг байна.

Байгаль хамгаалах сан:

Сангийн эхний үлдэгдэл 8765.4 мянган төгрөг дээр Орон нутгийн давсан орлогоос 9503.0 мянган төгрөг, хог хаягдлын хураамж 1312.5 мянган төгрөг, торгууль нөхөн төлбөр 2930.0 мянган төгрөг, анун-сүвд брьцааны мөнгө 200.0 мянган төгрөг, аймгаас морин эргүүлийн урамшуулалд 600.0 төгрөг буцаж орсон гүйлгээ 3035.5 мянган төгрөг нийт 8278.0 мянган төгрөг нэмэгдэж, МХГазрын актаар ОНОрлогод 6507.5 мянган төгрөг, МХГазрын газарт актаар 3280.0 мянган төгрөг, морин эргүүлийн урамшуулалд 1123.2 мянган төгрөг, данс андуурсан гүйлгээ 3035.5 мянган төгрөг, хог цэвэрлэгээнд 980.4 мянган төгрөг, нохой устгалд 575.0 мянган төгрөг, түймэр унтраахад шатахуунд 761.2 мянган төгрөг, цэцэрлэгт хүрээлэнгийн тээвэрт 270.0 мянган төгрөг, байгаль хамгаалагч эргүүл шалгалтаар явсан шатахуунд 2486.5 мянган төгрөг нийт 18282.6 мянган төгрөгийн зарлага гарч жилийн эцэст 8263.9 мянган төгрөг үлдсэн байна. Сангийн дансанд үлдэгдэлтэй байхад жилийн эцэст 1522.8 мянган төгрөгийн өглөг үүсэгсэн байна. Торгууль нөхөн төлбөрийн 2930.0 мянган төгрөгийг ОНОрлогын дансанд оруулах акт бичив.

Сум хөгжүүлэх сан:

Оны эхэнд 29301.5 мянган төгрөг дээр аймгаас санхүүжилт 81.0 сая төгрөг, зээлийн эргэн төлөлт хүү 46465.2 мянган төгрөг, Хүлэмж 3552.0 мянган төгрөг Сүүний цех 27400.0 мянган төгрөг зэрэг хөрөнгийн үнийг төвлөрүүлсэний орлого, акталсан хөрөнгө борлуулсаны орлого мотоцикл 2ш 300.0 мянган төгрөг, УАЗ-469 машины түрээсийн орлого 200.0 мянган төгрөг, төслийн худгийн эргэн төлөлт 2ш 287.4 мянган төгрөг нийт 159204.7 мянган төгрөгийн хөрөнгө төвлөрсөн байна. тус сангаас орон нутагт төсөл хэрэгжүүлхээр 7 иргэнд 18500.0 мянган төгрөг, Сөгнөгөр хангай хоршоонд 4.0 сая төгрөг нийт 22.5 сая төгрөгийн зээл олгосон байна. Тайлант оны эцэст сум хөгжүүлэх сангийн дансанд 166006.1 мянган төгрөг нь хяналтын түвшиний хуулгатай тохирч байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар 27 иргэн, 1 аж ахуйн нэгжээс нийт 72365.2 мянган төгрөгийн зээл, зээлээийн хүүгийн авлагатайг байна. Тайлант онд хугацаа хэтэрсэн 12 иргэний 5948.0 мянган төгрөг, үүнээс 2 иргэний 342.1 мянган төгрөг төлөгдөж 5605.9 мянган төгрөгийн авлага шүүхийн шийдвэрийн шатанд байна. Сангаас авсан зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй 1 иргэний 7500.0 мянган төгрөг, мөн жилийн эцэст графикайн дагуу төлөгдөөгүй 8500.0 мянган төгрөг, нийт 16000.0 мянган төгрөгийн хүүг тооцож, санд буцаан төвлөрүүлэх албан шаардлага бичив.

Торгууль нөхөн төлбөрийн 2930.0 мянган төгрөг, УАЗ-469 автомашины түрээсийн орлого 200.0 мянган төгрөг нийт 3130.0 мянган төгрөгийг ОНОрлогын дансанд оруулах акт бичив.

Сангийн хөрөнгө журмын дагуу зарцуулагдаагүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 9 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5. Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн. Эдгээр асуудлуудыг ААГ болон Лүн сумын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн

Залруулагдаагүй алдаа

6. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын Газар аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч 71.5 сая төгрөгийг аудитын явцад залруулсан болно

Тайлбар мэдүүлгийн захидал

7. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтнаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

8. Аймгийн Аудитын газраас тус тайланд дээрх хөрөнгө бэлтгэж тайлагнахтай холбогдон гарсан зөрчлүүдийг арилгуулахаар акт, албан шаардлага бичиж, хязгаарлалттай санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2013.03.18